



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

2024 оны 8 дугаар сар

**АУДИТЫН СЭДЭВ: МОНГОЛ
УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
АУДИТЫН ДҮГНЭЛТ**



АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	6
Монгол Улсын 2024 оны 2 улирлын байдлаарх макро эдийн засгийн төлөв байдал, төсвийн тодотгол хийх үндэслэл, төсөвт орсон өөрчлөлт.....	6
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ ДҮГНЭЛТ	8
Нэг. Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1-д заасны дагуу Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэх:.....	8
Хоёр. Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2-т заасан Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуурыг хангасан эсэх:.....	8
Гурав. Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.3-т заасан улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэх:.....	9
ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОСОН ОРЛОГО:	10
ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОСОН ЗАРЛАГА:	11
Нэг. Төсвийн урсгал зардал.....	11
Хоёр. Төсвийн хөрөнгө оруулалтын зардал:	12
ТАВ. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ:	17
ЗУРГАА. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР:	17
ДОЛОО. ДҮГНЭЛТ	18
<u>Хүснэгтийн жагсаалт</u>	
Хүснэгт 1. Төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал.....	9
Хүснэгт 2. Монгол улсын 2024 оны нэгдсэн төсвийн орлогын үзүүлэлт эдийн засгийн ангиллаар	10
Хүснэгт 3. Монгол улсын 2024 оны нэгдсэн төсвийн зарлагын үзүүлэлт эдийн засгийн ангиллаар.....	11
Хүснэгт 4. Шинээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний мэдээлэл	13
Хүснэгт 5. Төсөвт өртөг, санхүүжих дүнг нэмэгдүүлэн төлөвлөсөн төсөл, арга хэмжээний мэдээлэл .	13
Хүснэгт 6. Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт	15
Хүснэгт 7. Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт	15
Хүснэгт 8. Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээлэл	16
Хүснэгт 9. Нэгдсэн төсвийн суурь тэнцэл, тэнцвэржүүлсэн тэнцэл	17
Хүснэгт 10. Нийт өр төлбөр, хуулиар тогтоосон өрийн хязгаар	17
<u>Хавсралтын жагсаалт</u>	
Хавсралт 1. Нийслэлийн үнэт цаасны санхүүжилтийн эргэн төлөлтийн төлөвлөгөө	19
Хавсралт 2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө	20
Хавсралт 3. Монгол улсын 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөлөл	22



<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p> <p>Аудитын зорилго</p>	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</p> <p>Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 -т заасан бүрэн эрх, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтыг үндэслэн гүйцэтгэлээ.</p> <p>Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль эрх зүйн хүрээнд төсвийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй зарцуулахаар боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлсэн эсэхийг үнэлэх доорх асуултад хариулт өгөх зорилго тавьсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">➢ Монгол Улсын 2024 оны төсвийн тодотголыг үндэсний аюулгүй байдал болон улсын тогтвортой хөгжлийн бодлого, бодит шаардлагад нийцүүлж, эрх зүйн хүрээнд боловсруулсан эсэх;➢ Төсвийн тодотгол нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн тухай хуульд заасан шалгуурыг хангасан эсэх;➢ Төсвийн төслийг Засгийн газрын шинэчилсэн бүтэц бүрэлдэхүүн, чиг үүргийн өөрчлөлтөд нийцүүлж боловсруулсан эсэх,➢ Төсвийн орлого, зарлагын өөрчлөлт, Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хооронд хийсэн төсвийн зохицуулалтыг бодит шаардлага, тооцоо, судалгаанд үндэслэн төлөвлөсөн эсэх;➢ Төсвийн тодотголыг Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлж хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөсөн эсэх;➢ Төсвийн тодотголоор нэмж төлөвлөсөн улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн, ач холбогдлоор эрэмбэлж, хууль болон эдийн засгийн үр өгөөжтэй байх шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн эсэх;➢ Төсвийн төслийн тэнцвэржүүлсэн тэнцэл (ашиг, алдагдал)-ийг үндэслэлтэй тооцож, хуулийн шаардлагад нийцүүлж төлөвлөсөн эсэх.
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2022 оны А/67 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал” болон бусад холбогдох заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.</p> <p>Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.</p> <p>Аудитад төсвийн тодотголыг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлал, түүний дотор Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хуулийн 5 дугаар бүлэг, Өрийн удирдлагын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.9-д заасан шаардлагыг гол шалгуур болголоо.</p>
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Аудитыг Монгол Улсын нэгдсэн төсөв /улсын төсөв, Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн даатгалын сан, орон нутгийн төсөв/-ийн 2024 оны батлагдсан төсөв, 2024 оны 6 дугаар сарын байдлаарх төсвийн гүйцэтгэл /урьдчилсан/, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, төсвийн ерөнхийлөн захирагчид болон төсөл</p>



**Талуудын хүлээх
үүрэг, хариуцлага**

хөтөлбөрүүдэд орсон өөрчлөлт, үйл ажиллагааны үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад нэмж тусгасан хөтөлбөр арга хэмжээний мэдээ, тооцоо холбогдох баримт, санхүү, төсвийн мэдээ, үндсэн үзүүлэлтийг хамруулан гүйцэтгэв.

Засгийн газар нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд тухайн жилийн төсөвт тодотгол хийж, тухайн оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22, 23 дугаар зүйл, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5, 6, 7, 8 дугаар зүйлд заасан зарчим, шаардлагын дагуу, боловсруулж танилцуулгын хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг төрөөс баримтлах хөгжлийн бодлого, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд дүгнэлт гаргах үүрэг хүлээнэ.

**Аудитын бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Мөнхцацрал хэрэгжүүлж, Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор А.Даваадорж, П.Амарсанаа, Д.Мөнхжин, аудитор Н.Нямсүрэн, Ж.Нямцэцэг, А.Баясгалан, М.Пагамдулам болон Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын аудитын менежер Ю.Энхтуяа, аудитор Б.Идэрбалжинням нар батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Хүндрэл бэрхшээл

Төрийн аудитын байгууллагаас тухайн жилийн төсвийн тодотголд аудит хийх эрх зүйн зохицуулалт тодорхой бус, Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлт гарган Улсын их хуралд өргөн барих, хэлэлцүүлэх цаг хугацаа нэн хязгаарлагдмал байгаа нь хүндрэл бэрхшээл үүсгэсэн.



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ДНБ	ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН
ЗГ	ЗАСГИЙН ГАЗАР
ИТХ	ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
ОН	ОРОН НУТАГ
ТЕЗ	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
ТЭЗҮ	ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ
УЕП	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР
УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
ХЗДХС	ХУУЛЬ, ЗҮЙ ДОТООД ХЭРГИЙН САЙД
ХНХС	ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД
ХХААХҮС	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД
ЦХХХС	ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД
ЦДАШ	ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМ
ШЕЗ	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ
ЭЗХЯ	ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭМДС	ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН
ЭМС	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
ЭХС	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД



НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2024 оны 2 улирлын байдлаарх макро эдийн засгийн төлөв байдал, төсвийн тодотгол хийх үндэслэл, төсөвт орсон өөрчлөлт

1.1. Монгол Улсын 2024 оны эхний улирлын байдлаарх нэрлэсэн ДНБ 16,400.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 19.0 хувиар, мөнгөний нийлүүлэлт 41,500.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 31.9 хувиар, ажиллах хүчний оролцооны түвшин 59.4 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар тус тус өссөн, инфляцын түвшин 5.1 хувь болж, өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна¹.

1.2. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн тодотголыг боловсруулахдаа эдийн засгийг 5.6 хувиар өсөхөөр, гадаад худалдааны нийт бараа эргэлтийг 27.9 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 5.4 тэрбум ам.долларын ашигтай гарахаар, экспортын голлох нэрийн бүтээгдэхүүн болох чулуун нүүрсний борлуулалтын хэмжээг 18.1 сая тонноор нэмэгдүүлж 78.1 сая тонн байхаар макро эдийн засгийн төлөв байдлын төсөөллийг үндэслэл болгосон байна.

1.3. Улсын Их Хурлаас 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулиар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 25,855.1 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 27,360.5 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,505.4 төгрөгийн алдагдалтай байхаар баталжээ.

1.4. Улсын Их Хурлаас 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 25,855.1 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийг 27,360.5 тэрбум төгрөг, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,505.4 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар тус тус баталсан.

1.5. Төсвийн гүйцэтгэл 2024 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 14,947.2 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 12,911.3 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн тэнцэл 1,287.5 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна².

1.6. Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнд 2024 оны 7 дугаар сарын 2-ны өдөр 126 гишүүнтэй шинэ парламент бүрдэж, 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын төлөөллөөс бүрдсэн хамтарсан Засгийн газар байгуулагдсан.

1.7. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон нь Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх нөхцөлийг бүрдүүлж, улс төрийн гурван намаас “ХҮРДТАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ЗОРИГ” гэрээ байгуулж, эдийн засгийн суурийг тэлэх эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх зорилт дэвшүүлсэн нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагыг бий болгосон байна.

1.8. Ийнхүү Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, 34.1.1, 34.1.4-т заасан төсөвт тодотгол хийх нөхцөл бүрдсэн тул Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн ХЭГ/1462 дугаар албан бичгээр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль болон холбогдох бусад хуулиудад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад өргөн мэдүүлж, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу хэлэлцүүлэх хугацааг товлож өгөхийг хүссэн байна.

¹ Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга

² Эх сурвалж: Сангийн яам, Төсвийн бодлогын газар



1.9. Засгийн газраас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль зэрэг 15 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар, Төрийн өмчийг Нийслэлийн өмчид шилжүүлэх тухай тогтоолын төсөл, Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах төслийг тус тус батлуулахаар УИХ-д өргөн мэдүүлжээ.

1.10. Улс төрийн намуудын гэрээнд суурилсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хөгжилд чиглэсэн томоохон төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1-т “Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг баримтлахгүй байх нөхцөл байдал”-ыг бүрдүүлсэн тул “Шинэ 30 жилийн хөгжилд чиглэсэн төсвийн бодлого”-д нийцүүлж Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагуудыг өөрчлөх нь зүйтэй гэж Сангийн яам үзсэн байна.

1.11. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг дараах хүрээнд өөрчлөх хуулийн төслийг боловсруулжээ. Үүнд:

- Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээг ДНБ-ий 30 хувиас хэтрүүлэхгүй байх;
- Нэгдсэн төсвийн суурь тэнцэл ДНБ-ий хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх;
- Засгийн газрын өрийг нэрлэсэн дүнгээр тооцох;

1.12. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 28,872.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 36.4 хувь, нийт зарлагын дээд хэмжээг 30,487.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 38.5 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл -1,615.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.0 хувийн алдагдалтай, нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ 27,269.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 34.4 хувь, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,603.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.0 хувийн ашигтай байх, Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн хэмжээг 47,529.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 60 хувьтай тэнцэхээр тооцсон байна.

1.13. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 28,872.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 36.4 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 30,487.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 38.5 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,615.4 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 2.0 хувь байхаар төлөвлөжээ.

1.14. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулинд өөрчлөлт оруулах хуулийн төслөөр нэгдсэн төсвийн дараах үзүүлэлтүүдийг өөрчлөн төлөвлөсөн байна. Үүнд:

- Монгол Улсын төсөвт 2024 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 3,017.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 28,872.5 тэрбум төгрөг;
- Монгол Улсын төсвөөс 2024 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 3,127.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 30,487.9 тэрбум төгрөг;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн тогтворжуулалтын санд 2024 онд хуримтлуулах дүнг 35.2 тэрбум төгрөгөөр бууруулж 478.6 тэрбум төгрөг;
- Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.1, 12.1.3, 12.1.6 болон 28¹.1-д заасан зориулалтаар хийх гадаад, дотоод зээллэгийн дээд хэмжээг 537.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 3,951.8 тэрбум төгрөг;
- Өрийн удирдлагын тухай хуулийн 12.1.5-д заасан зориулалтаар Засгийн газрын авч ашиглах гадаад төслийн зээлийн дээд хэмжээг 984.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 2,209.0 тэрбум төгрөг;
- Тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад 2024 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн хэмжээг 1,346.1 тэрбум төгрөгөөр бууруулж 1,940.4 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн байна.



1.15. Монгол Улсын 2024 оны төсвийн тодотголыг хөгжлийн бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болох техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийг боловсруулах, төсвийн хөрөнгө оруулалтыг бүсчилсэн хөгжил, Улаанбаатар хотын хэт төвлөрөл, түгжрэлийг бууруулах, Туул голоос Хөшигийн хөндий рүү чиглэсэн шинэ их тойруу дэд бүтэц зэрэг бүтээн байгуулалтын төслүүдийг санхүүжүүлэхэд чиглүүлсэн байна.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас дараах дүгнэлтийг гаргаж байна.

Нэг. Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1-д заасны дагуу Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэх:

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн бодлоготой нийцэж байна.

Мөн Засгийн газрын нэрлэсэн үнээр тооцсон өрийн үлдэгдэл дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх харьцаа 2024 онд 44.7 хувьд хүрэх төсөөлөлтэй байхаар тооцоолон тусгасан нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3-д заасан төсөв, санхүүгийн аюулгүй байдлын бодлогын зохистой харьцаанд байна.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2-т заасан Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуурыг хангасан эсэх:

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнд хамтарсан Засгийн газар байгуулагдаж бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4-т "төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх" гэж заасныг үндэслэн боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйл болон тус хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөд тусгасан төсвийн тусгай шаардлагуудыг хангаж байна. Үүнд:

- ✓ Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон;
- ✓ Нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,603.5 тэрбум төгрөгийн ашигтай буюу ДНБ-ий 2.0 хувьтай тэнцүү;
- ✓ Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 28.3 хувь буюу тусгай шаардлагаар тогтоосон 30 хувиас хэтрээгүй байна;
- ✓ Засгийн газрын өрийн нэрлэсэн үнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь 44.7 хувь буюу тусгай шаардлагаар тогтоосон 60 хувиас хэтрээгүй байна.



Хүснэгт 1. Төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал

№	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага	Тодотгосон төсвийн төсөлд тусгасан байдал	Тусгай шаардлага хангасан байдал
1	6 дугаар зүйл: 6.1.1. “нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх”	Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасан шаардлагын дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон бөгөөд 2024 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 7,386.6 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 182.5 ам.доллар байхаар тооцсон байна.	6 дугаар зүйлийн 6.1.1-т заасан тусгай шаардлагыг хангасан
Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангасан байдал			
1	6 дугаар зүйлийн 6.1.2-т орсон нэмэлт өөрчлөлт: “Нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх” • “4.1.12. “нэгдсэн төсвийн суурь зарлага” гэж нийт зарлагаас үнэт цаас болон гадаад зээлээр санхүүжих зардлыг хасаж тооцсон дүнг; • 4.1.13. “нэгдсэн төсвийн суурь тэнцэл” гэж нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогоос суурь зарлагыг хассан дүнг.”	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 28,872.5 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн суурь зарлага 27,269.0 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,603.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.0 хувийн ашигтай байхаар тооцсон байна.	6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан тусгай шаардлагыг хангасан
2	6 дугаар зүйлийн 6.1.3-т орсон нэмэлт өөрчлөлт: “нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх”	Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ 22,431.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 28.3 хувьтай байна.	6 дугаар зүйлийн 6.1.3-т заасан тусгай шаардлагыг хангасан
3	6 дугаар зүйлийн 6.1.4-т орсон нэмэлт өөрчлөлт: “Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх”	Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 35.9 их наяд төгрөгтэй тэнцэж байгаа бөгөөд үүний ДНБ-д эзлэх хэмжээ 44.7 хувьтай тэнцүү байна.	6 дугаар зүйлийн 6.1.4-т заасан тусгай шаардлагыг хангасан

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллага

Гурав. Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.3-т заасан улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэх:

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан дээрх өөрчлөлтүүд нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөө, баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлүүдтэй нийцсэн байна.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг 6 бүлэг, 8 тэргүүлэх чиглэлийн 24 зорилгын хүрээнд 194 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд улсын төсөв 2,705.6 тэрбум төгрөг, бусад эх үүсвэр 1,589.0 тэрбум төгрөг, орон нутгийн төсөв 247.0 тэрбум төгрөг, гадаадын зээл, тусламж, хөрөнгө оруулалт 4,747.6 тэрбум төгрөг, төр хувийн хэвшлийн түншлэл 4,515.1 тэрбум төгрөг, нийт 13,885.2 тэрбум төгрөгийг улсын төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээр бүрдүүлэхээр баталсан.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 27 дугаар зүйлийн 27.1.8 дахь заалтын дагуу Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд туссан зорилтуудыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн



төсөл, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь чиглэсэн байна.

Төсөвт зохицуулалт хийхдээ 2024 оны Төсвийн тухай хуулиар хэрэгжүүлэхээр баталсан хөтөлбөр, арга хэмжээг хэвээр үлдээж, нийт 39 төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх 98 хөтөлбөр, хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон шалгуур үзүүлэлтийг боловсруулсан байна.

ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОСОН ОРЛОГО:

3.1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нийт орлого ба тусламжийн дүнг 2024 оны батлагдсан төсвөөс 2,917.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 30,639.5 тэрбум төгрөгөөр төсөвлөсөн байна.

Хүснэгт 2. Монгол улсын 2024 оны нэгдсэн төсвийн орлогын үзүүлэлт эдийн засгийн ангиллаар /тэрбум төгрөг/

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГЫН ҮЗҮҮЛЭЛТ	2024	2024	Зөрүү	Өсөлтийн хувь
	Бат	Тод төс		
Нийт орлого ба тусламжийн дүн	27,722.1	30,639.5	2,917.4	10.5
Тогтворжуулалтын сан	513.6	478.6	(35.2)	(6.8)
Үндэсний баялгийн сан	1,353.3	1,288.5	(64.8)	(4.8)
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	25,855.2	28,872.5	3,017.3	11.7
Татварын орлого	23,953.5	26,939.2	2,985.7	12.5
Татварын бус орлого	1,901.7	1,933.3	31.6	1.7

Эх сурвалж: Сангийн яам

3.2. Төсвийн тодотголоор 2024 оны батлагдсан төсвөөс тогтворжуулалтын санд төвлөрүүлэх орлогыг 35.2 тэрбум төгрөгөөр бууруулж 478.6 тэрбум төгрөг байхаар тооцсон нь нүүрсний зах зээлийн дундаж үнийг 2024 оны эцэс хүртэл буурч хэлбэлзэнэ гэж тооцсонтой холбоотой байна.

3.3. Төсвийн тодотголоор 2024 оны батлагдсан төсвөөс үндэсний баялгийн санд төвлөрүүлэх орлогыг 64.8 тэрбум төгрөгөөр бууруулж 1,288.5 тэрбум төгрөгөөр тооцсон нь Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1.^а, 11.1.2^д-т заасны дагуу Ирээдүйн өв санд 789.0 тэрбум төгрөгийг АМНАТ-с хуваарилахаар, Хуримтлалын санд 499.5 тэрбум төгрөгийг уул уурхайн олборлолт, ашигт малтмалын баяжуулах салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ногдол ашиг байхаар тус тус тооцоолсонтой холбоотой байна.

3.4. Төсвийн тодотголоор төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийг 2024 оны батлагдсан төсвөөс 3,017.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 28,872.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ны 36.4 хувьтай тэнцэхээр төлөвлөсөн байна. Үүнд: Татварын орлогыг 2,985.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж төсөвлөсөн нь голлон нөлөөлж байна.

3.5. Төсвийн тодотголоор тэнцвэржүүлсэн орлого болон ДНБ-д эзлэх хувь хэмжээ нь 2023 оны 05 дугаар сарын 31-ний Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн хязгаараас 3,017.3 тэрбум төгрөгөөр хэтэрсэн боловч шинэчилсэн хуулийн төсөлтэй нийцэж байна.

3.6. Нүүрсийг 2024 онд 60 сая тонныг экспортлохоор төлөвлөснөөс эхний хагас жилийн байдлаар 67.7 хувийн гүйцэтгэлтэй буюу 40.6 сая тонн хүрч, өмнөх оны мөн үеэс 11.5 сая тонноор буюу 38 хувиар өссөн тул төсвийн тодотголд жилийн эцэст экспортыг 78.1 сая тоннд хүргэхээр тооцсон байна. Харин нүүрсний гол импортлогч орнуудын эдийн засаг, гадаад хүчин

³ ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувь;

⁴ Хуримтлалын сан энэ хуулийн 12.9-д заасны дагуу төвлөрүүлсэн ногдол ашгаас дараах зарчмаар хуваарилсан эх үүсвэрээс бүрдэнэ;



зүйл нүүрсний үнийн бууралтаас шалтгаалж төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байх эрсдэлтэй байна.

3.7. Засгийн газраас хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулсан, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах зэргээр экспортыг дэмжсэн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр зорьсон байна.

3.8. Төсвийн тодотголоор орон нутгийн төсвөөс Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 451.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 1,595.3 тэрбум төгрөгөөр төлөвлөжээ. Энэ нь төсвийн орлого тасарсан тохиолдолд оны эцэст орон нутгийн төсөвт хүндрэл үүсгэж болзошгүй байна.

Мөн Нийслэл Улаанбаатар хотын төсвөөс Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 210.7 тэрбум төгрөгөөр бууруулж тооцсон нь өөрийн орлогыг дараах зардлуудад нэмж зарцуулахаар төлөвлөсөнтэй холбоотой байна. Үүнд:

- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8, 25 дугаар зүйлийн 25.1.8 дахь заалтад заасан орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын 2024 оны байр ашиглалттай холбоотой тогтмол зардал;
- Улаанбаатар хотод дамжуулан зээлдүүлсэн гэрээний 2024 оны суурь зардалд хянагдаагүй хуримтлагдсан өр төлбөр;
- Засгийн газрын 2024 оны 201 дүгээр тогтоолоор 3 транч бүхий үнэт цаасыг дотоодын зах зээлд нээлттэй хэлбэрээр санал болгосон бөгөөд 2024 онд төсвийн эх үүсвэрээс төлөх хүүгийн эхний төлбөр;
- Нийтийн тээврийн үйлчилгээний зардлын санхүүжилт;
- Хот нийтийн тохижилт үйлчилгээний зардал;
- Сэлбэ дэд төвийн төсөл арга хэмжээний газар чөлөөлөлт, нөхөн олговрын нэмэлт зардал.

ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОСОН ЗАРЛАГА:

Нэг. Төсвийн урсгал зардал

1.1 Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд Монгол Улсын төсвийн нийт зарлагыг 3,127.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 30,487.9 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь төсвийн алдагдлын хэмжээг 110.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд нөлөөлжээ.

Хүснэгт 3. Монгол улсын 2024 оны нэгдсэн төсвийн зарлагын үзүүлэлт эдийн засгийн ангиллаар /тэрбум төгрөг/

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ҮЗҮҮЛЭЛТ	2024	2024	Зөрүү	Өсөлтийн хувь
	Бат	Тод төс		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГОД НИЙЦҮҮЛСЭН)	27,360.5	30,487.9	3,127.4	11.4
УРСГАЛ ЗАРЛАГА	21,221.9	22,431.5	1,209.7	5.7
Бараа, үйлчилгээний зардал	8,883.9	9,198.0	314.1	3.5
Зээлийн үйлчилгээний төлбөр	1,173.6	1,173.6	-	-
Татаас ба урсгал шилжүүлэг	11,164.3	12,059.9	895.6	8.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,273.3	8,071.0	1,797.7	28.7
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	(134.7)	(14.6)	(120.1)	(89.2)

Эх сурвалж: Сангийн яам

1.2. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд нийт урсгал зардлыг 1,209.6 тэрбум төгрөг, хөрөнгийн зардлыг 1,797.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, эргэж төлөгдөх цэвэр зээлийг 120.1 тэрбум төгрөгөөр бууруулж төлөвлөсөн байна.

1.3. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт орсны дагуу 9 Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд 187.6 тэрбум төгрөгийн төсвийн зохицуулалт хийж, яамдын чиг үүргийн өөрчлөлттэй холбоотойгоор 31 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийг 1,755.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийг нийт 127.1 тэрбум төгрөгөөр бууруулсан байна.



1.4. Засгийн газар нь Эрчим хүчний салбарт зах зээлийн өрсөлдөөнийг бий болгох, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлэх, салбарын үнэ тарифыг бодит өртгөө нөхдөг байх зарчимд шилжүүлэх бодлогын зорилт дэвшүүлсэн байна. Уг зорилтын хүрээнд эрчим хүчний салбарт шинэчлэл хийх шилжилтийн үеийн зардлыг санхүүжүүлэхэд зориулж 131.1 тэрбум төгрөгийг нэмэгдүүлэн тусгасан бөгөөд цаашид тарифын өсөлтийн өөрчлөлтөөс үүдсэн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлсээр байвал төсөвт дарамт учруулахаас гадна эрчим хүчний суурь тарифын өсөлт нь нийгэм, эдийн засагт сөрөг үр дагаврыг авчирч болзошгүй юм.

Хоёр. Төсвийн хөрөнгө оруулалтын зардал:

2.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ "МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО"-ЫН БАРИМТ БИЧИГТЭЙ УЯЛДСАН БАЙНА.

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн 680.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 төсөл арга хэмжээ нь Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, Монгол Улсын Их хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдсан байна.

Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан 4.2 "Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно" зорилтын хүрээнд 1, 5.3" Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ" зорилтын хүрээнд 1, 8.1 "Бүс нутгийн эдийн засгийн интеграцад дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр бүрэн холбогдож, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлнэ" зорилтын хүрээнд 1, 9.3 "Орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж байгаа дагуул хотуудтай олон улсад өрсөлдөгч метрополитан болж хөгжинө" зорилтын хүрээнд 7, 9.5 "Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлнэ" гэсэн зорилтын хүрээнд 2 төсөл арга хэмжээг тус тус төлөвлөжээ.

2.2 ТӨСВИЙН ТОДОТГОЛЫН ТӨСӨЛД ӨРГӨН БАРЬСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШИГ, НИЙГМИЙН АЧ ХОЛБОГДЛЫН БОЛОН ТӨСӨВТ ӨРТГИЙН ТООЦООЛОЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Төсвийн тодотголоор 10.0 тэрбум төгрөгөөс 676.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий нийт 960.6 тэрбум төгрөгийн 9 шинэ төсөл, арга хэмжээг 384.4 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдаас төсвийн төсөлд тусгуулахаар хөрөнгө оруулалтын санал ирүүлэхдээ төсөл, арга хэмжээг аймаг, нийслэлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулсан эсэх тодорхойгүй, техник эдийн засгийн үзүүлэлт, зураг төслийн төсөвт өртгийг урьдчилсан судалгаанд үндэслэн төлөвлөсөн байдал хангалтгүй байна.

Шинээр хэрэгжүүлэх техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах 9 төсөл, арга хэмжээг 2024 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн боловч урьдчилсан судалгаа бүрэн хийгдээгүй байгаа нь төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байх, төлөвлөсөн санхүүжилтийн эх үүсвэрийг ашиглах боломжгүй болох эрсдэлтэй байна.



Хүснэгт 4. Шинээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний мэдээлэл

/сая төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх	Дуусах	Тодотголоор /төсөвт өртөг/	Тодотголоор /санхүүжих дүн/
1	Бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/	2024	2024	60,000.0	60,000.0
2	Засгийн газрын нэг цэгийн үйлчилгээний цогцолборын зураг төсөв, барилга угсралтын ажлыг эхлүүлэх /Улаанбаатар, Номтын ам, Төв, Хөшигийн хөндий/	2024	2027	676,272.0	100,000.0
3	20 минутын хотын бүтээн байгуулалтын төслүүдийн төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар/	2024	2024	10,000.0	10,000.0
4	Бүтээн байгуулалтын төслүүдийн нэгдсэн менежментийн зөвлөх үйлчилгээ /Улаанбаатар/	2024	2024	50,000.0	50,000.0
5	Зэвсэгт хүчний тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	2024	2024	40,576.3	40,576.3
6	"Шинэ тойрог авто зам" төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар/	2024	2024	16,900.0	16,900.0
7	"Хөшигийн хөндий туннел" төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар, Төв, Хөшигийн хөндий/	2024	2024	55,300.0	55,300.0
8	Улаанбаатар хотын "Шинэ их тойруу" хурдны зам төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар/	2024	2024	23,000.0	23,000.0
9	"Өөдөө тэмүүлэх Монгол" ган татлагат гүүрэн байгууламжийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс Хүрхрэн ам хүртэл/	2024	2024	28,600.0	28,600.0

Эх сурвалж: Сангийн яам

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд тусгаж баталсан 5 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 70.6 тэрбум төгрөгөөр, санхүүжих дүнг 89.7 тэрбум төгрөгөөр нэмж төлөвлөсөн байна.

Хүснэгт 5. Төсөвт өртөг, санхүүжих дүнг нэмэгдүүлэн төлөвлөсөн төсөл, арга хэмжээний мэдээлэл

/сая төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжих он		Монгол Улсын 2024 оны ТТХ-д тусгасан		Нэмж төлөвлөсөн	
		Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, харьяа байгууллагуудын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	2024	2024	4,896.0	4,896.0	1,800.0	1,800.0
2	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн монголын талын хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/	2024	2026	494,000.4	181,600.0	68,830.0	68,830.0
3	Улаангом сумаас Тэс, Малчин, Хяргас, Зүүнговь, Цагаанхайрхан, Баруунтуруун сумд хүртэлх чиглэлийн хатуу хучилттай авто замын зураг төсөв /Увс/	2024	2024	1,100.0	50.0	-	1,050.0
4	"Шинэ Хархорум" хотын усны эх үүсвэрийн судалгаа, байр зүйн зураглал, инженер, геологийн судалгаа, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон техник, эдийн засгийн үндэслэл /Архангай, Өвөрхангай/	2024	2024	30,000.0	15,000.0	-	15,000.0
5	Дулааны станцын өргөтгөл, 21 МВт /Хөвсгөл, Мөрөн сум/	2024	2025	16,639.9	4,992.0	-	3,008.0

Эх сурвалж: Сангийн яам



2.3 УЛСЫН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БАГЦЫН ЗАДАРГААГ ТОДОРХОЙ БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлсэн саналыг үндэслэн нийт 463.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 8, Үндэсний аюулгүй байдлын саналыг үндэслэн 40.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

УИХ-ын 2024 оны 40 дүгээр тогтоолын 2 дахь хэсэгт “Засгийн газрын байгууллагуудын нэгдсэн байрын цогцолборын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг холбогдох дэд бүтэц, Их тэнгэрийн болон Номтын амны ерөнхий төлөвлөлттэй нягт уялдуулсан цогц төсөл байхаар төлөвлөж, барилга угсралтын ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу Тагнуулын ерөнхий газарт хариуцуулан хэрэгжүүлэх” гэж заасан боловч Монгол улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын багцад төлөвлөсөн байна.

Монгол улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын багцын “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, харьяа байгууллагуудын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/”, Зам тээврийн сайдын багцын “Шинэ тойрог авто зам” төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв”, “Улаанбаатар хотын “Шинэ их тойруу” хурдны зам төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв” төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэл шаардлагыг нарийвчлан тодорхойлоогүй байна.

Монгол Улсын Шадар сайдын багцын “Бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/”, Монгол Улсын сайд, 20 минутын хот үндэсний хорооны даргын багцын “20 минутын хотын бүтээн байгуулалтын төслүүдийн төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар/” төсөл, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх ажлын жагсаалтыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна.

2.4 ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН АЖИЛД ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Монгол Улсын сайд, 20 минутын хот үндэсний хорооны даргын багцын “Бүтээн байгуулалтын төслүүдийн нэгдсэн менежментийн зөвлөх үйлчилгээ /Улаанбаатар/” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх “техник, эдийн засгийн үндэслэл” боловсруулах ажлын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, зарцуулах зардал, төсвийг тооцож төлөвлөхөд баримтлах жишиг үнэ, ажлын даалгавар боловсруулахад тавигдах шаардлага, хүлээн авахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

2.5 НИЙСЛЭЛИЙН ҮНЭТ ЦААСНЫ ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГЫГ ХАНГУУЛЖ, ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Нийслэлийн ИТХ-ын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн “Нийслэлийн дотоод үнэт цаас гаргахыг дэмжих тухай” 48 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” болон нийслэлийн дунд хугацааны бодлогын баримт бичигт туссан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор Нийслэлийн үнэт цаасыг дотоодын зах зээлд гаргаж арилжаалахыг дэмжсэн байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн “Нийслэлийн дотоод үнэт цаас гаргах тухай” 201 дугаар тогтоолоор 500.0 хүртэлх тэрбум төгрөгийн нийслэлийн үнэт цаасыг дотоодын зах зээлд гаргахыг Нийслэлийн Засаг даргад зөвшөөрсөн ба тус үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг баталсан байна.



Хүснэгт 6. Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт

/сая төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Үнэт цаас гаргах он	2024 онд санхүүжих дүн
1	Бөөрөлжүүтийн цахилгаан станц	2024	300,000.0
2	Ариутгах бохир усны Туул-1 коллектор болон үерийн байгууламж	2024	50,000.0
3	Авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлийн ажил	2024	150,000.0
Нийт дүн			500,000.0

Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 201 дүгээр тогтоолын хавсралт

Мөн Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн “Нийслэлийн дотоод үнэт цаас гаргах тухай” 264 дугаар тогтоолоор 500.0 хүртэлх тэрбум төгрөгийн нийслэлийн үнэт цаасыг дотоодын зах зээлд гаргахыг Нийслэлийн Засаг даргад зөвшөөрч, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсан ба зах зээлд санал болгох бэлтгэл ажил хийгдэж байна.

Нийслэлийн ИТХ-ын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн хурлын 88 дугаар тогтоолоор Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 2,638.2 тэрбум төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

Хүснэгт 7. Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө

оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт

/сая төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх он	Дуусах он	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
Нийслэлийн дотоод үнэт цаасны хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ				702,609.4	692,000.0
Шинэ					
1	Авто зам, замын байгууламжийн завсар, шинэчлэлт, зураг төвийн ажил /Улаанбаатар хот/	2024	2024	270,600.0	270,600.0
2	Ариутгах бохир усны Туул-1 коллекторын байгууламжийн ажил / Улаанбаатар хот	2024	2024	40,000.0	40,000.0
3	Үерийн хамгаалалтын шугам сүлжээ барилга байгууламж /Улаанбаатар хот/	2024	2024	6,000.0	6,000.0
4	Эрчим хүч хуримтлуурын станцын ажил	2024	2024	296,000.0	296,000.0
5	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган дахин барилгажуулах төслийн инженерийн шугам сүлжээний ажил /Улаанбаатар хот/	2023	2024	34,898.9	26,900.0
6	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжүүлэх гадна инженерийн шугам сүлжээний ажил /Улаанбаатар хот/	2022	2024	55,110.5	52,500.0
Нийслэлийн гадаад үнэт цаасны хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ				1,646,200.0	1,646,200.0
Шинэ					
1	Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хороолол	2024	2024	1,646,200.0	1,646,200.0
Дүн				2,348,809.4	2,338,200.0

Эх сурвалж: НИТХ-ын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 88 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт



Нийслэлийн дотоод үнэт цаасны хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээний зураг төсөл боловсруулах шатанд буюу магадлалаар бүрэн баталгаажуулаагүй байгаа нь тайлант онд санхүүжилтийг бүрэн ашиглахгүй байх, төсөвт өртөг нэмэгдэх, төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэх боломжгүй болох сөрөг үр дагаврыг бий болгож байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

- Ариутгах Бохир усны Туул-1 коллекторын байгууламжийн ажил /Улаанбаатар хот/,
- Үерийн хамгаалалтын шугам сүлжээ, барилга байгууламж /Улаанбаатар хот/ байна.

Нийслэлийн дотоод үнэт цаасны хөрөнгөөр 5 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд нийт 312.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хүснэгт 8. Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээлэл /сая төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч	Гэрээний нийт үнийн дүн	Олгосон санхүүжилт	Санхүүжилтийн хувь
1	Бөөрөлжүүтийн цахилгаан станцын төсөлд хөрөнгө оруулах зорилгоор “Нийслэлийн хөгжлийн сан хувийн хос” ХХК-ийн нэгж эрх худалдан авах	Нийслэлийн хөгжлийн сан хувийн хос” ХХК	300,000.0	300,000.0	100.0
2	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Төмөр замын гармын зүүн талаас Тэс петролиум ШТС хүртэл)	Улаанбаатар зам засвар, арчлалтын газар	5,985.0	1,795.5	30.0
3	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Тэс петролиум ШТС-ээс Номин худалдааны төв хүртэл)	Улаанбаатар зам засвар, арчлалтын газар	6,300.0	1,890.0	30.0
4	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Номин худалдааны төвөөс Авто худалдааны цогцолборын уулзвар хүртэл)	Улаанбаатар зам засвар, арчлалтын газар	8,375.0	2,512.0	30.0
5	22-н товчооны авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Авто худалдааны цогцолборын уулзвараас Баруун аймаг салдаг уулзвар хүртэл)	Улаанбаатар зам засвар, арчлалтын газар	8,950.0	2,685.0	30.0
6	Нийслэлийн үнэт цаас гаргахад шаардагдах үнэт цаасны шимтгэл	-	3,391.3	3,391.3	100.0
Нийт			333,001.3	312,273.8	93.8

Эх сурвалж: Нийслэлийн ЗДТГ

“Нийслэлийн хөгжлийн сан хувийн ХОС ТЗК” ХХК-ийн нэгж эрхийн хөрөнгө оруулалтад 300.0 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 2,388.2 тэрбум төгрөгийг төлөвлөсөн ба сангийн нэгж эрхийг худалдан авч Бөөрөлжүүтийн цахилгаан станцын төсөлд хөрөнгө оруулах зорилгоор 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Нийслэлийн Засаг дарга “Нийслэлийн хөгжлийн сан хувийн хос” ХХК-тай 300.0 тэрбум төгрөгийн үнэ бүхий нэгж эрх худалдаж, худалдан авах гэрээг байгуулсан байна.

Өрийн удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.7-д заасан “Засгийн газрын зээллэгийн хөрөнгө, өрийн баталгааны хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах талаар шаардлагатай арга хэмжээг авах” Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг хэрэгжүүлж Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.



ТАВ. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ:

5.1. Тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 28,872.5 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 30,487.9 тэрбум төгрөг, нийт гадаад зээл 2,209.0 тэрбум төгрөг, орон нутгийн үнэт цаас 1,009.9 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,603.5 тэрбум төгрөгийн ашигтай, тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон төсвийн тэнцэл 1,615.4 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 9. Нэгдсэн төсвийн суурь тэнцэл, тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/

Д/д	Үзүүлэлт	2024 бат	2024 год	Зөрүү
1	Нийт орлого ба тусламжийн дүн	27,722.1	30,639.5	2,917.4
2	Төсвийн тогтворжуулалтын сан	513.6	478.6	(35.2)
3	Үндэсний баялагийн сан	1,353.3	1,288.5	(64.8)
4	Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	25,855.2	28,872.5	3,017.3
5	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	27,360.5	30,487.9	3,127.4
6	Нэгдсэн төсвийн суурь тэнцэл	-	1,603.5	1,603.5
7	Төсвийн тэнцэл (Тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон)	(1,505.4)	(1,615.4)	(110.0)

Эх сурвалж: Сангийн яам

5.2. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-д “Нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухай жилийн ДНБ-ний 2 хувь буюу түүнээс дээш хувийн ашигтай байх” гэж заасан төсвийн төлөвлөлтийн шаардлагыг хангасан байна.

ЗУРГАА. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР:

Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2024 оны хагас жилийн байдлаар 30,339.6 тэрбум төгрөг, 2024 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэл 35,392.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ны 44.7 хувьд хүрэх төлөвтэй байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөр, хуулиар тогтоосон өрийн хязгаар /тэрбум төгрөг/

Д/д	Өрийн хэсэгсэл	2023-IV	2024-II	2024 ХБГ*
1	Засгийн газрын дотоод өр	234.1	141.6	993.4
1.1	Үнэт цаас	234.1	141.6	993.4
2	Засгийн газрын гадаад өр	30,274.6	29,346.5	31,429.9
2.1	Үнэт цаас	9,371.7	8,716.3	8,907.0
2.2	Зээл	20,902.9	20,630.2	22,522.9
3	Засгийн газрын бусад өр	264.9	759.0	2,969.4
3.1	Засгийн газрын өрийн баталгаа	29.5	254.5	1,969.4
3.2	"Барих-шилжүүлэх" төрлийн концесс	230.9	-	-
3.3	Орон нутгийн зээллэг	4.5	504.5	1,000.0
	Нийт дүн (1+2+3)	30,773.5	30,247.1	35,392.7
	Засгийн газрын нийт өр (ӨҮЦ)	26,582.9	26,157.8	30,877.3
	Засгийн газрын нийт өр (НҮ)	30,773.5	30,247.1	35,392.7
	Хуулиар тогтоосон өрийн хязгаар	65.0%	60.0%	60.0%
	ДНБ оны үнээр	68,871.7	78,880.0	79,215.6
	Засгийн газрын өр (ӨҮЦ)/ДНБ	38.6%	33.2%	39.0%
	Засгийн газрын өр (НҮ)/ДНБ	44.7%	38.3%	44.7%

Эх сурвалж: Сангийн яам

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-д оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Засгийн газрын өрийг өнөөгийн үнэ цэнээр тооцдог байсныг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулахдаа нэрлэсэн дүнгээр тооцдог болгон өөрчлөх саналыг тусгасан байна.

Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуульд гадаад зээлээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын хэмжээг 1,225.0 тэрбум төгрөгөөр баталсан боловч тодотголоор хөрөнгийн зардалд 740.0 тэрбум төгрөг, урсгал зардалд 54.0 тэрбум, эргэн төлөгдөх нөхцөлтэй дамжуулан зээлд 190.0 тэрбум төгрөг, нийт 984.0 тэрбум төгрөгийн 11 арга хэмжээг гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр нэмж төлөвлөсөн байна.



ДОЛОО. ДҮГНЭЛТ

Монгол улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна. Үүнд:

1. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэгдэн батлагдаж, зарим яамдын эрхлэх асуудал, чиг үүрэгт өөрчлөлт орсонтой холбоотойгоор шинэ бүтцийг дагалдуулан хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хөтөлбөр, арга хэмжээг шилжүүлж, төсөвт зохицуулалт хийсэн байна.
2. Цаашид дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулахгүй байх, төсвийн тусгай шаардлагыг дунд, урт хугацаанд тогтвортой байдлыг хадгалж, дагаж мөрдөх нь төсвийн тогтвортой байдлыг бэхжүүлэх суурь нөхцөл болно.
3. Шинэчилсэн төсвийн тусгай шаардлагын нөлөөгөөр хөрөнгийн зардал дунд хугацаанд нэмэгдэхээр байгаа нь эдгээр хөрөнгө оруулалтуудтай холбоотой урсгал зардлыг өсгөх нөлөөтэй байна. Иймд нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх тусгай шаардлагыг хангах үүднээс Төрийн хэмнэлтийн тухай хуулийг чанд мөрдөн, хэрэгжилтэд тогтмол хяналт тавих шаардлагатай байна.
4. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны бусад хөгжлийн бодлогод нийцсэн, нотолгоо-үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт, арга барилыг сайжруулж, урсгал болон хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн үйл явцыг бүрэн уялдуулах шаардлагатай байна.
5. Хөгжлийн төслүүдийг нийгэм, эдийн засгийн үр ашгийн тооцоолол, судалгаанд үндэслэн сонгон шалгаруулж, Улсын Их Хурлаар батлуулах, эдгээр хөгжлийн төслүүдийг эдийн засагт хэт халалт үүсгэх, импортыг эрс нэмэгдүүлэх эрсдэлийг тооцож, төсөв, санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэх замаар өндөр инфляц, өрхийн бодит орлого, амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах шаардлагатай байна.
6. Төсвийн тодотголоор нийт 960.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 9 шинэ төсөл, арга хэмжээг 384.4 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, 5 төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 89.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.
7. Шинээр хэрэгжүүлэх техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажлуудыг 2024 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөж, санхүүжүүлэх дүнг тусгасан ба төсөл хэрэгжүүлэх боломжит хугацааны хувьд төлөвлөсөн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн ашиглах боломжгүй болох эрсдэлтэй байна.



ХАВСРАЛТ

Хавсралт 1. Нийслэлийн үнэт цаасны санхүүжилтийн эргэн төлөлтийн төлөвлөгөө

/сая төгрөг/

№	Дотоод үнэт цаасны эргэн төлөлт	Бондын хүү	Эргэн төлөлтийн эх үүсвэр	2024	2025	2026	2027	2028	2029	Нийт дүн
1	ЗАСГИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ 201 ДҮГЭЭР ТОГТООЛООРХ БОНДЫН ЭРГЭН ТӨЛӨЛТ									
1.1	Транч 1 дүн	14%	Бөөрөлжүүт цахилгаан станц төслийн эх үүсвэрээс	20,942	42,000	42,000	321,000	-	-	425,942
1.1.1	Бондын эргэн төлөлт			-	-	-	300,000	-	-	300,000
1.1.1	Бондын хүү			20,942	42,000	42,000	21,000	-	-	125,942
1.2	Транч 2 дүн	13%	Нийслэлийн төсвийн эх үүсвэрээс	6,500	13,000	106,500	-	-	-	126,000
1.2.1	Бондын эргэн төлөлт			-	-	100,000	-	-	-	100,000
1.2.2	Бондын хүү			6,500	13,000	6,500	-	-	-	26,000
1.3	Транч 3 дүн	12%	Нийслэлийн төсвийн эх үүсвэрээс	6,000	106,000	-	-	-	-	112,000
1.3.1	Бондын эргэн төлөлт			-	100,000	-	-	-	-	100,000
1.3.2	Бондын хүү			6,000	6,000	-	-	-	-	12,000
1.4	Нийт эргэн төлөлт			33,442	161,000	148,500	321,000	-	-	663,942
1.4.1	Бондын эргэн төлөлт			-	100,000	100,000	300,000	-	-	500,000
1.4.2	Бондын хүү			33,442	61,000	48,500	21,000	-	-	163,942
2	ЗАСГИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ 264 ДҮГЭЭР ТОГТООЛООРХ БОНДЫН ЭРГЭН ТӨЛӨЛТ									
2.1	Транч 1 дүн	12%	Нийслэлийн төсвийн эх үүсвэрээс	-	35,520	35,520	123,520	111,520	96,000	402,080
2.1.1	Бондын эргэн төлөлт			-	-	-	100,000	100,000	96,000	296,000
2.2.2	Бондын хүү			-	35,520	35,520	23,520	11,520	-	106,080
2.2	Транч 2 дүн	15%	Нийслэлийн төсвийн эх үүсвэрээс	-	15,000	115,000	-	-	-	130,000
2.2.1	Бондын эргэн төлөлт			-	-	100,000	-	-	-	100,000
2.2.2	Бондын хүү			-	15,000	15,000	-	-	-	30,000
2.3	Транч 3 дүн	15%	Нийслэлийн төсвийн эх үүсвэрээс	-	119,600	-	-	-	-	119,600
2.3.1	Бондын эргэн төлөлт			-	104,000	-	-	-	-	104,000
2.3.2	Бондын хүү			-	15,600	-	-	-	-	15,600
2.4	Нийт эргэн төлөлт			-	170,120	150,520	123,520	111,520	96,000	651,680
2.4.1	Бондын эргэн төлөлт			-	104,000	100,000	100,000	100,000	96,000	500,000
2.4.2	Бондын хүү			-	66,120	50,520	23,520	11,520	-	151,680
3	ЗАСГИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ 265 ДУГААР ТОГТООЛООРХ БОНДЫН ЭРГЭН ТӨЛӨЛТ									
3.1	Гадаад бонд дүн	10%	Сэлбэ дэд төв төслийн эх үүсвэрээс	-	169,800	169,800	169,800	169,800	1,698,000	2,377,200
3.1.1	Бондын эргэн төлөлт			-	-	-	-	-	1,698,000	1,698,000
3.2.2	Бондын хүү			-	169,800	169,800	169,800	169,800	-	679,200
3.2	СВОП зардлын дүн	4%	Нийслэлийн төсвийн эх үүсвэрээс	-	73,008	78,849	85,157	91,969	-	328,982
3	ШИНЭ ТОЙРОГ ЗАМ ТӨСЛИЙН ҮНЭТ ЦААСНЫ ЭРГЭН ТӨЛӨЛТ									
4.1	Дотоод бонд дүн	15%	Нийслэлийн төсвийн эх үүсвэрээс	-	33,750	67,500	483,750	-	-	585,000
4.1.1	Бондын эргэн төлөлт			-	-	-	450,000	-	-	450,000
4.2.2	Бондын хүү			-	33,750	67,500	33,750	-	-	135,000
5	НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР ТӨЛӨХ БОНДЫН ЭРГЭН ТӨЛӨЛТ									
5.1	Нийт төсвийн эх үүсвэрээс шаардагдах дүн			12,500	565,678	573,169	862,227	373,289	96,000	2,482,862
5.1.1	Бондын эргэн төлөлт			-	204,000	200,000	550,000	100,000	96,000	1,150,000
5.1.2	Дотоод бондын хүү			12,500	118,870	124,520	57,270	11,520	-	324,680
5.1.3	Гадаад бондын хүү			-	169,800	169,800	169,800	169,800	-	679,200
5.1.4	СВОП зардал			-	73,008	78,849	85,157	91,969	-	328,982

Эх сурвалж: Нийслэлийн Засаг даргын тамгын газар



Хавсралт 2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө /сая төгрөг/

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	2024 оны		Зөрүү	Өөрчлөлт-ийн хувь
		Бат	Тод		
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга	185.0	185.0	-	
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	185.0	185.0	-	
2	Монгол Улсын Их Хурлын дарга	100.0	100.0	-	
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	100.0	100.0	-	
3	Монгол Улсын Ерөнхий сайд	648,431.7	105,629.2	(542,802.5)	-83.7%
	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	644,002.5	101,200.0	(542,802.5)	-84.3%
	үүнээс: Ирээдүйн өв санд	520,083.2	-	(520,083.2)	-100.0%
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	4,429.2	4,429.2	-	
4	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	510.0	510.0	-	
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	510.0	510.0	-	
5	Санхүүгийн зохицуулах хорооны дарга	2,737.7	2,737.7	-	
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,737.7	2,737.7	-	
6	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	132.6	2,472.9	2,340.3	1765.4%
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	132.6	2,472.9	2,340.3	1765.4%
7	Монгол Улсын Шадар сайд	15,941.5	16,099.0	157.6	1.0%
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	15,941.5	16,099.0	157.6	1.0%
8	Монгол Улсын Шадар сайд	-	25.0	25.0	
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	-	25.0	25.0	
9	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	175.0	175.0	-	
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	175.0	175.0	-	
10	Гадаад харилцааны сайд	6,000.0	6,000.0	-	
	Дипломат төлөөлөгчийн газрууд	6,000.0	5,100.0	(900.0)	-15.0%
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	-	900.0	900.0	
11	Сангийн сайд	18,181,474.2	18,784,694.9	603,220.7	3.3%
	Татварын ерөнхий газар	10,675,146.9	11,143,087.7	467,940.7	4.4%
	үүнээс: Төсвийн тогтворжуулалтын санд	513,710.9	478,553.6	(35,157.3)	-6.8%
	үүнээс: Ирээдүйн өв санд	833,224.2	-	(833,224.2)	-100.0%
	Гаалийн ерөнхий газар	6,727,915.6	6,792,915.6	65,000.0	1.0%
	Сангийн яам	211,194.0	281,474.0	70,280.0	33.3%
	Гадаад тусламжийн орлогоос санхүүжих	558,000.0	558,000.0	-	
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	9,217.6	9,217.6	-	
12	Хууль зүй, дотоод хэргийн сайд	83,749.0	81,276.1	(2,472.9)	-3.0%
	Улсын бүртгэлийн ерөнхий газар	45,000.0	45,000.0	-	
	Цагдаагийн ерөнхий газар	2,700.0	2,700.0	-	
	Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	1,552.9	1,552.9	-	
13	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	426,173.4	360,261.8	(65,911.7)	-15.5%
	Ашигт малтмал, газрын тосны газар	421,903.3	355,971.6	(65,931.7)	-15.6%
	Үндэсний геологийн алба	110.0	130.0	20.0	18.2%
14	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	4,160.2	4,160.2	-	
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	4,160.2	4,160.2	-	
15	Батлан хамгаалахын сайд	38,185.4	38,185.4	-	
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	38,185.4	38,185.4	-	
16	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	1,485.5	1,485.5	-	
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	1,485.5	1,485.5	-	
17	Боловсролын сайд	5,857.9	5,857.9	-	
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,857.9	5,857.9	-	
18	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	38,454.4	39,034.4	580.0	1.5%
	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	850.0	850.0	-	
	Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	2,535.1	2,535.1	-	
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	35,069.3	35,649.3	580.0	1.7%
19	Зам, тээврийн сайд	175,300.0	105,656.0	(69,644.0)	-39.7%



1	Иргэний нисэхийн ерөнхий газар	150,000.0	80,000.0	(70,000.0)	-46.7%
8	Зам, тээврийн хөгжлийн яам	300.0	300.0	-	
	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	25,000.0	25,356.0	356.0	1.4%
1	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	54,588.5	54,588.5	-	
9	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	54,588.5	54,588.5	-	
2	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	8,665.5	8,665.5	-	
0	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	8,665.5	8,665.5	-	
2	Эрүүл мэндийн сайд	5,555.4	5,555.4	-	
1	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5,555.4	5,555.4	-	

Эх сурвалж: Сангийн яам

Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл			Тодотгол			Зөрүү		
					Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл		Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2024 он	2025 он	2026 он	2024 он	2025 он	2026 он	2024 он	2025 он	2026 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	7.0	6.5	5.4	5.6	8.0	6.5	(1.4)	1.5	1.1
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	8.5	6.0	6.0	6.5	7.9	4.0	(2.0)	1.9	(2.0)
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	25,855.1	27,757.3	29,155.8	28,872.5	30,001.3	32,873.7	3,017.4	2,244.0	3,717.9
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	34.9	33.4	32.4	36.4	31.6	31.4	1.5	(1.8)	(1.0)
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	27,360.5	29,417.3	30,955.8	30,487.9	32,992.0	35,849.5	3,127.4	3,574.7	4,893.7
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	37.0	35.4	34.4	38.5	34.7	34.2	1.5	(0.7)	(0.2)
5	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	(1,505.4)	(1,660.0)	(1,800.0)	(1,615.4)	(2,990.7)	(2,975.9)	(110.0)	(1,330.7)	(1,175.9)
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	(2.0)	(2.0)	(2.0)	(2.0)	(3.1)	(2.8)	-	(1.1)	(0.8)
6	Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/				27,269.0	28,101.0	30,779.5	27,269.0	28,101.0	30,779.5
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь				34.4	29.6	29.4	34.4	29.6	29.4
7	Нэгдсэн төсвийн суурь тэнцэл /тэрбум төгрөг/				1,603.5	1,900.3	2,094.1	1,603.5	1,900.3	2,094.1
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь				2.0	2.0	2.0	2.0	2.0	2.0
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/				47,529.4	57,008.5	62,823.5	47,529.4	57,008.5	62,823.5
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь				60.0	60.0	60.0	60.0	60.0	60.0
	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	44,400.0	49,800.0	54,000.0				(44,400.0)	(49,800.0)	(54,000.0)
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	60.0	60.0	60.0				(60.0)	(60.0)	(60.0)
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	2,351.9	2,437.7	2,461.8	2,351.9	2,850.4	2,931.8	-	412.7	470.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	3.2	2.9	2.7	3.0	3.0	2.8	(0.2)	0.1	0.1
	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	4,989.2	2,056.7	1,538.5				(4,989.2)	(2,056.7)	(1,538.5)
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	6.7	2.5	1.7				(6.7)	(2.5)	(1.7)
	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	6,273.3	6,620.8	6,971.7				(6,273.3)	(6,620.8)	(6,971.7)
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	8.5	8.0	7.7				(8.5)	(8.0)	(7.7)

Эх сурвалж: Сангийн яам

